

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2026 оны 06 дугаар сарын 24-ний өдөр, Лхагва гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 5
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6 – 43
1.	<i>Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх асуудал</i>	8 – 24
2.	<i>Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал</i>	24 – 25
3.	<i>Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./</i>	26 – 43

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 06 дугаар сарын 24-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Б.Жавхлан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 58 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

*Томилолттой: О.Алтангэрэл, Л.Оюун-Эрдэнэ;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Э.Болормаа, А.Ганбаатар, Н.Номтойбаяр,
Н.Учрал, Б.Хэрлэн, О.Цогтгэрэл.*

Нэг.Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч Ж.Сүхбаатар, Г.Эрдэнэбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх саналыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт танилцуулав.

Нэр дэвшүүлсэн байгууллага болон нэр дэвшигчдээс Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяагийн тавьсан асуултад нэр дэвшигч Ж.Сүхбаатар, Г.Эрдэнэбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Зулпхар, Л.Гантөмөр нар үг хэлэв.

Б.Жавхлан: 1.Нэр дэвшигч Ж.Сүхбаатарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 3
Бүгд: 21
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Нэр дэвшигч Г.Эрдэнэбатыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 3
Бүгд: 21
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 16 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт "энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ" гэж заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл тус бүрээр санал хураалт явуулав.

Б.Жавхлан: 1.Монгол Улсын Засгийн газраас 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай 129 дүгээр конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 12
Бүгд: 21
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Монгол Улсын Засгийн газраас 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын аж үйлдвэр болон худалдаа дахь хөдөлмөрийн хяналтын тухай 81 дүгээр конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 12
Бүгд: 21
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал нарын 19 гишүүнээс 2026.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 12
Бүгд: 21
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг 16 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Н.Номтойбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, Сангийн дэд сайд Б.Хулан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Батцэцэг, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Гантуяа, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх Т.Энхтүвшин, Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Ц.Одхүү, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Энхбаяр, Л.Гангэрэл, Үндэсний аудитын газрын Бодлого төлөвлөлт, инновацын газрын дарга Х.Баярмаа, мөн газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Нандинжаргал, Санхүүгийн аудитын газрын аудитын менежер С.Цогтбаатар, И.Эрдэнэцэцэг, Б.Энхбаатар, В.Эрдэнэцогт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Ариунболд, Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатар, Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Г.Даваадалай, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, мөн яамны Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогт, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга М.Мөнхсүх, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн хөрөнгө оруулалтын

удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Бат-Эрдэнэ, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Батжаргал, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Эрсдэлийн удирдлага, хяналтын газрын дарга Л.Наранчимэг, мөн компанийн Нэгдсэн бүртгэл, тайлагналын хэлтсийн менежер Б.Цэрэндэлгэр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Сангийн сайд З.Мэндсайхан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ч.Ундрэм, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 29 минут үргэлжилж, 32 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 71.9 хувийн ирцтэйгээр 17 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.ЖАВХЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 24-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “ҮНДСЭН ХУУЛЬ” танхим
15 цаг 58 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 24-ний өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааныг эхлүүлье.

Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026-ны оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулна.

32 гишүүнээс 19 гишүүд ирцэд бүртгүүлсэн байна.

Оюунсайханы Алтангэрэл гишүүн, Жудагийн Баярмаа гишүүн, Лувсаннъямын Гантөмөр гишүүн, Болдын Жавхлан гишүүн, Лхагвын Мөнхбаатар гишүүн, Цэвэгдоржийн Туваан гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Аюушийн Ариунзаяа гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Сархадын Зулпхар гишүүн, Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн, Чинбатын Ундрам гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Амгаланбаатарын Ганбаатар гишүүн, Тогмидын Доржханд гишүүн, Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн. Эдгээр 19 гишүүд ирцдээ орсон байна.

Байнгын хорооны хуралдааны ирцийг Та бүхэнд танилцууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг мөн танилцуулъя.

Өнөөдөр өмнөх долоо хоногийн даргын зөвлөлийн хуралдаанаар хуралдаад өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд 9 асуудал хэлэлцэх байгаа.

Гэвч зарим ажлын хэсгийн гишүүд дээр эцэслэж нягтлах зүйлүүд байна. Зарим ажлын хэсэг хуралдаагүй гээд хэд хэдэн шалтгаанаар гурав, дөрвөн ч асуудал хойшлуулах нь байна шүү. Гишүүд анхааралтай сонсоорой.

Нэг.Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх санал. Энэ асуудлаа хэлэлцээд явна.

Хоёр.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчийн сонгол тайлан. Энэ асуудлыг хойшлуулна.

Гурав.Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонголын тайлан. Мөн ирц хүрээгүй ийм шалтгаантай байгаа учраас энэ асуудал мөн хойшилж байна.

Дөрөв.Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцэх эсэх асуудал.

Тав.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Зургаа.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Энэ хууль байгаа.

Мөн дараагийн хууль нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд.

Энэ хоёр асуудал мөн ажлын хэсэг дахиж хуралдаж ойлголцолд хүрэх шаардлагатай байгаа учраас хойшлууллаа.

Найм.Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл.

Ес.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Анэ асуудлын ажлын хэсэг нь хуралдаж амжаагүй байгаа юм байна.

Тийм учраас Байнгын хороонд орж ирсэн асуудал байхгүй учраас хойшлууллаа.

Ингээд 9-өөс 5 асуудал ингээд хойшлогдлоо. Өнөөдрийн хуралдаанд 4 асуудал хэлэлцэхээр боллоо шүү.

Хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцууллаа.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/
Ингээд нэгдүгээр асуудалдаа оръё.

**Нэг.Үндсэн хуулийн цэцийн гишүүнд
нэр дэвшүүлэх асуудал**

Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлсэн саналыг хэлэлцье.

Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлын даргын 2026 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн Улсын Их Хурал 01/7528 дугаар албан бичгээр Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх саналыг Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлсэн.

Нэр дэвшигч Жамъянхорлоо овогтой Сүхбаатарын танилцуулгыг Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт танилцуулна.

Ж.Сүхбаатар нэр дэвшигчийг оруулаарай.

С.Бямбацогт даргын микрофоныг нээгээрэй.

С.Бямбацогт: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатарыг нэр дэвшүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулж байна.

Жамъянхорлоогийн Сүхбаатар 1975 онд одоогийн Дархан-Уул аймгийн Дархан сум буюу Дархан хотод төрсөн. Ам бүл 2.

Ж.Сүхбаатар 1993 онд Дархан хотын 3 дугаар дунд сургууль, 1997 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр, 1999 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийг Хууль зүйн ухааны магистрын зэрэгтэй төгссөн.

Америкийн Нэгдсэн Улс, Швед, Казахстан зэрэг улсад мэргэжлийн болон бусад сургалтад хамрагдсан.

Нийтийн эрх зүй буюу захиргааны эрх зүй, сонгуулийн эрх зүйгээр мэргэшсэн. Судалгаа хийдэг. Докторант.

Ж.Сүхбаатар 1997-2005 онд “Улаанбаатар эрдэм” дээд сургуульд захиргааны эрх зүйн багш, ахлах багш.

1997-1999 онд Улсын Их Хурлын гишүүний орон тооны ажилтан.

1999-2001 онд Улсын Их Хурал дахь Монгол Ардын Хувьсгалт Намын бүлгийн ажлын албанд Хуулийн бодлогын зөвлөх.

2001-2006 онд Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, нарийн бичгийн дарга.

2006-2008 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга.

2008-2012 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга.

2012-2013 онд Монгол Ардын намын удирдах зөвлөлийн гишүүн, намын нарийн бичгийн дарга.

2016 онд Монгол Ардын Хувьсгалт Намын Ерөнхий нарийн бичгийн дарга.

2019-2020 онд Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх.

2020-2024 онд Улсын Их Хурлын гишүүн.

2020-2022 онд Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга.

2022-2023 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга.

2025 оны 12 дугаар сараас 2026 оны 04 дүгээр сар хүртэл Улсын Их Хурлын даргын Хууль зүйн бодлогын зөвлөх.

2026 оны 04 дүгээр сараас Ерөнхий сайдын Хууль зүйн бодлогын зөвлөхөөр тус тус ажиллаж байна.

Ж.Сүхбаатар төрийн албанд 20 гаруй жил ажилласан бөгөөд төрийн улс төрийн захиргааны, тусгай албанд удирдах болон өндөр албан тушаалуудад удаа дараа сонгогдох буюу томилогдон ажилласан.

Төрийн удирдах ажлын өргөн мэдлэг, туршлагатай.

Ж.Сүхбаатар нь төрийн ажил, эрх зүйн онол, практикийн өндөр мэдлэг чадвар, бэлтгэгдсэн байдал, туршлагыг үндэслэн Үндсэн хуулийн гишүүнд нэрийг нь дэвшүүлж байна.

Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Б.Жавхлан: Баярлалаа. Нэр дэвшигч Ганбат овогтой Эрдэнэбатын танилцуулгыг мөн Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт танилцуулна. С.Бямбацогт дарга нар микрофоныг нээгээрэй.

С.Бямбацогт: Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд Ганбатын Эрдэнэбатыг дэвшүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч Ганбатын Эрдэнэбат нь 1972 онд Улаанбаатар хотод төрсөн. 54 настай, эхнэр, 2 хүүхэдтэй хамт амьдардаг.

Г.Эрдэнэбат 1990 онд ерөнхий боловсролын 31 дүгээр сургууль, 1994 онд Цагдаагийн дээд сургуулийн эрх зүйч мэргэжлээр, 1997 онд Батлан хамгаалахын их сургуулийг хууль зүйн магистр зэрэгтэй төгссөн.

Г.Эрдэнэбат 1994-1995 онд Хилийн цэргийн ангид офицер.

1996-1998 онд Батлан хамгаалахын их сургуульд багш.

1998-2000 онд Хил хамгаалах ерөнхий газарт хуулийн зөвлөх.

2000-2005 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд багш.

2005-2009 онд Монгол Улсын Их Сургуулийн Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Сургалтын албаны дарга.

2009-2010 онд Ерөнхийлөгч Тамгын газарт хуулийн асуудал хариуцсан туслах.

2010-2013 онд Улсын ерөнхий прокурорын газарт хэлтсийн дарга.

2013-2019 онд Монгол Улсын ерөнхий прокурорын орлогч.

2019-2022 онд Монголын криминологчдын холбооны ерөнхийлөгч.

2021-2023 онд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны ахлах референт.

2024-2025 онд Улсын Их Хурлын Тамгын газарт ажилтан.

2026 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс Улсын Их Хурлын Тамгын газрын дэд даргаар ажиллаж байна.

Г.Эрдэнэбатын төрийн алба болон эрдэм шинжилгээ, судалгаа, боловсролын байгууллагад ажилласан туршлагыг үндэслэн Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэрийг нь дэвшүүлж байна.

Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Жавхлан: Баярлалаа. Нэр дэвшигчдийн танилцуулга болон нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд байна уу?

Д.Энхтуяа гишүүнээр тасаллаа. /алх цохив/

Аюушийн Ариунзаяа гишүүний микрофоныг нь өгье.

А.Ариунзаяа: Үндсэн хуулийн цэцийн хоёр ч гишүүний томилгооны асуудал маш удаан хугацаанд орж ирж чадахгүй маш удаан хугацаанд л Та хоёрын эрэл хайгуул хийгдэж одоо орж ирж байна.

Үндсэн хуулийн цэцийн даргын хугацаа дуусаад даруй нэг жил өнгөрсөн.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн ажлаа өөрийн хүсэлтээр өгөөд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарын бичгийн даргын албан тушаалд томилогдоод нэлээд удаж байна.

Тэгээд ийм удаан хугацаанд эрэл хайгуул болж орж ирж байгаа Та хоёр хамгийн шилдэг хоёр л байгаа юм болов уу даа л гэж үзэж байгаа шүү дээ. Тийм ээ.

Тэгээд би яах вэ, Та хоёрын талаар нэг их айхтар олон юм яримааргүй байна. Угаасаа улс төрийн хүрээнийхэн Та хоёрыг хэн гэдгийг мэднэ шүү дээ. Та хоёр улс төрийн хүрээнээс орж ирж байгаа хоёр. Энэ бол маргаангүй.

Ганцхан юм хүсмээр байна. Мэргэжилдээ үнэнч байгаарай. Хуулиа дээдлээрэй. Үндсэн хуулийн цэцийнхээ Үндсэн хуулиа хамгаалж шийдвэрүүдийг гаргаарай.

Үндсэн хуулийн цэцийн нэр хүнд сүүлийн хоёр жилийн хугацаанд нэлээд унасан шүү. Итгэх итгэл үнэхээрийн буурсан.

Онолын хүмүүс, багш нар төдийлөн сайн биш байдаг юм байна гэдгийг харж улс төрийн хүрээнээс оруулж ирж байгаа болов уу гэж бодож байна.

Ж.Сүхбаатар нэр дэвшигч. Та өөрөө улс төрийн дуулиан, улс төрийн хэрэгт хутгаж хохирсон хүний нэг. Танд хэрэг тохож цагаадсан хүний нэг.

Тэгэхээр улс төр ямар заваан байдаг вэ гэдгийг Та мэдэхийн дээдээр мэдэж байгаа.

Улс төрчдийн шахаасаар дахиад элдэв янзын асуудал цэц дээр гарах вий дээ. Энэ дээр л үнэхээрийн санаа зовж байна. Могойн хорлолд өрт өртөх вий.

Үнэхээрийн мэргэжилдээ үнэнч, ард түмнийхээ төлөө, хуулийнхаа талд байгаарай л гэж хүсье дээ. Өөр хэлэх юм алга. Асуулт биш. Үг хэллээ.

Б.Жавхлан: Д.Энхтуяа гишүүний микрофоныг нээе.

Д.Энхтуяа: Сая А.Ариунзаяа гишүүн ч ерөнхийдөө бас хэлж байна.

Тэгэхээр Үндсэн хуулийн цэц ер нь улс төрөөс хол байх ёстой юм уу? Яг энэ Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд улс төрийн өндөр нарийн мэргэшилтэй хуульч байх ёстой гэсэн ийм зүйл заалт байна л даа.

Гэтэл амьдрал дээр яг сонгон шалгаруулалт дээр л ийм улс төрийн нарийн мэргэшсэн хүн байх ёстой гэсэн ийм заалттай хэрнээ улс төрийн бас томилгоо хийгддэг. Тийм ээ.

Гэтэл улс төрийн томилгооноос хол байх ёстой, улс төрөөс хол байх ёстой, ангид байх ёстой гээд үзээд байна л даа. Тийм ээ. Ихэнхдээ ингээд холиод.

Тэгээд хоёр нэр дэвшигчийг хувь хүнийх нь хувьд хоёуланг нь маш сайн мэднэ.

Ер нь улс төрийн намуудын томилгооноос орж ирж байгаа ч гэсэн хувь хүмүүс нь өөрсдөө хуульчийн хувьд Монгол Улсын хуулийн салбарт өөрсдийгөө таниулсан ийм мундаг хуульчид л даа.

Тэгэхээр яах аргагүй бас улс төртэй холбоод байна. Тийм ээ. Ний нуугүй л ярья. Тийм ээ. Тэгэхээр Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай юм уу? Энэ улс төрийн өндөр мэргэжил, мэдлэгтэй мэргэшсэн хүмүүс байх ёстой гэж заачхаад нөгөө талаасаа улс төрөөс ангид бай гээд ингээд байгаа чинь ер нь зөв юм уу? Энэ дээр Та хоёр хуульчийнхаа хувьд хариулт өгөөч.

Хоёрт нь, уг нь миний бодлоор ер нь маш сайн хуульч, эрх зүйч хүмүүс тэнд ард иргэдийн, зөвхөн улс төрийн хүрээнийхний асуудлыг шийдэх биш. Тийм ээ. жирийн иргэдийн Үндсэн хуулийн зөрчил болсон маргааныг шийдвэрлэж явах ёстой л гэж ойлгоод байгаа шүү дээ.

Тэгэхээр Та хоёр энэ дээр ямар байр суурьтай байдаг юм? Магадгүй дэмжигдээд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр явах юм бол энэ хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үздэг үү? Ийм асуулт байна.

Тэгээд тодруулъя.

Б.Жавхлан: Д.Энхтуяа гишүүн асуулт асуулаа. Нэр зааж асуух гэж асуусан уу Тийм ээ. Хоёулангаас нь.

Танилцуулгынхаа дарааллаар хариулаад явъя. Тэгэх үү? Эхлээд Жамъянхорлоогийн Сүхбаатар нэр дэвшигч хариулъя.

Ж.Сүхбаатар: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Гишүүн Д.Энхтуяагийн асуулт бол зүй ёсоор тавигдаж байгаа асуулт л даа.

Үндсэн хуулийн цэц буюу олон улсад “Үндсэн хуулийн шүүх” гэж явж байгаа. Францад “Үндсэн хуулийн зөвлөл” гээд явдаг. Тэгээд олон загварууд бий л дээ.

Монгол Улсын Үндсэн хуульд анх боловсруулахдаа яг шүүх гэж заагаагүй. Өнөөдрийг хүртэл зарим нь Үндсэн хуулийн шүүх биш гэж үздэг улсууд байдаг.

Гэхдээ яг одоо шийдвэр гаргаж байгаа процесс, бүх юм нь бусад улс оронтой харьцуулах юм бол яг л Үндсэн хуулийн шүүхийн энэ загвараар явж байгаа.

Зүгээр манай онцлогийн тухайд та хөндөж байгаа учраас улс төрийн хүрээнээс орж ир хүрч байгаа гээд түрүүн А.Ариунзаяа гишүүн ч хэллээ, та ч бас хэлж байна.

Ер нь яах вэ, улс орнуудад янз янзын л загвар байгаа. Та бүхэн мэдэж байгаа. Америкийн Нэгдсэн Улсын Дээд шүүх бол хоёр намын томилгоогоор явдаг. Гол юм нь бол процесс нь ил тод. Тэгээд хувь хүний биеэ даасан байдлыг нь л гол нь их харгалздаг. Тухайн шүүх нь бас өөрөө шийдвэр гаргаж байгаа процесс нь хүлээн зөвшөөрөгдөхүйц байх ёстой. Түүнээс нууж хаагаад байх юм байхгүй. Ардчилсан нийгмийн тогтолцоондоонд ер нь улс төрийн намын харьяалалтай улсууд янз янзын албан тушаалд тавигддаг.

Тэгэхээр тухайн хүний биеэ даасан байх чанар урьд өмнө явж байсан асуудлууд гэж ярьдаг.

Миний тухайд танд хэлэхэд Үндсэн хуулийн цэц бол улс төрөөс хол байх ёстой юу гэдэг бол илүү тийм зарим тохиолдолд онолын яг талаасаа хол байх ёстой гэж үздэг.

Тэгэхдээ Үндсэн хуулийн эрх зүйн маргаан өөрөө төрийн дээд байгууллага төрийн дээд албан тушаалтны асуудлуудыг шийдвэрлэдэг учраас өөрийнх нь гаргаж байгаа үр дагавар нь Үндсэн хуулийн эрх зүйн үр дагавар өөрөө улс төрийн үр дагаврыг үүсгэдэг.

Тийм учраас энэ утгаараа үзэх юм бол улс төрийн эрх мэдлийн тэр орбит тэр хүрээнээс гадуур шийдвэр гаргадаг уу гэвэл үгүй. Үр дагавар нь шууд Үндсэн хуулийн түвшний маргаан шийддэг учраас улс төрөөс огт хамааралгүй гэж хэлэхгүй. Хамгийн гол асуудал бол энэ хамтын удирдлагын байгууллага учраас таны дараагийн асуулт болсон хуульд өөрчлөлт оруулах уу гэж байна.

Тэгээд энэ хуульд маань өөрчлөлт ороогүй бараг 30-аад жил болсон явж байгаа байх. Тэгээд олон удаагийн оролдлогууд явж байгаа.

Тэгэхээр энэ цэцийн хуульд тодорхой хэмжээний өөрчлөлтүүд орох шаардлагатай.

Тэгээд хамгийн гол юм нь Та бүхэн мэдэж байгаа. Үндсэн хуулийн үзэл баримтлал, амин сүнс. Ч.Чимид багшийн анх ярьж байсан тэр Үндсэн хуулийн цэцийн тэр агуулгынх нь хүрээнд явах ёстой. Мэдээж цаашдаа ч гэсэн Үндсэн хуулийн цэцийн гаргаж байгаа шийдвэрүүд олон нийтийн анхаарал татсан, Та бүхний хувьд ч гэсэн шүүмжилмээр яримааргүй зүйлүүд мэдээж гарах байх.

Гол юм нь би процедурын хувьд их сайн хийгээд өгөх юм бол, процедур нь зөв байх юм бол тухайн хүн нь тэр механизмдаа захирагдаад явдаг л гэж хэлэх байна. Тийм.

Б.Жавхлан: Ганбатын Эрдэнэбат нэр дэвшигчийн микрофоныг өгье.

Г.Эрдэнэбат: Баярлалаа. Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Д.Энхтуяа гишүүний асуултад хариулахад энэ үнэхээр их нюанстай зүйлийг та асуулаа. Зөв.

Энэ үнэхээр Монгол Улсын Үндсэн хуульд заасан Үндсэн хуулийн цэцийн гишүүнд тавигддаг улс төр болон хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдэг бол зайлшгүй тавигдах ёстой шаардлага мөн гэж боддог.

Улс төр гэдгийг хүмүүс маргаан хэлэлцүүлэг явдаг энэ процессоос нь болоод их муухай зүйл гэж төсөөлөөд байх шиг байна.

Гэтэл яг үнэнээ хэлэхэд улс төр гэдэг бол энэ улс орноо хөгжүүлэх бодлогын л тухай ярьж байгаа. Өнөөдрийн Улсын Их Хурлын гишүүн гишүүд 126 хүн Монгол Улсаасаа аль л өнгөтэй өөдтэй гээд сонгогдсон, улсаа хөгжүүлэх бодлогын төлөө л ухаанаа уралдуулж байгаа хүмүүс.

Тэгээд энэ хууль, төрийн бодлого өөрөө улс төрийг нь ойлгож, өөрөөр хэлбэл ямар бодлогоор хууль гараад, ямар зорилго тавьж, ямар арга хэрэгслээр энэ улс орныг хөгжүүлэх гээд байгаа юм бэ гэдгийг нь ойлгож мэдэхгүй хүн тухайн бодлого болсон хууль, Улсын Их Хурлын шийдвэр, тэгээд бусад албан

тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа өөрөө Үндсэн хуулийнхаа үзэл санаанд нийцэж байна уу, үгүй юу гэдгийг ойлгож шүүх боломжгүй.

Тэгэхээр сонгодог утгаараа зөв өнцгөөс нь харах юм бол улс төр гэдэг бол тийм бохир заваан зүйл биш. Энд байгаа бүх хүмүүс хоорондоо маргалдаж мэтгэлцэгдээд л янз бүрийн байдлаар төсөөлөгдөөд байгаа болохоос биш бүгдээрээ энэ улсаа хөгжүүлэх гэж бодоод байгаа хүмүүс шүү дээ.

Тэгээд энэ бодлогыг бид шүүж ярих гэж байгаа хүн. Энэ бодлогын мөн чанар ер нь яагаад ийм шийдвэр гарсан бэ гэдгийг ойлгодоггүй байж байж шүүнэ гэдэг бол их зовлонтой асуудал.

Тийм учраас энэ зүй ёсны асуудал. Харин сая манай нэр дэвшигч Ж.Сүхбаатар мөн хэллээ. Энэ шийдвэрийг гаргахдаа тухайн үеийн улс төрийн албан тушаалтны эрх мэдэлтэй хүмүүсийн нөлөөлөлд нь автахгүйгээр Үндсэн хуулийн үзэл санаа, төрийн бодлого, хоёроо харьцуулаад шийдвэр гаргах нь бол бас зайлшгүй шаардлага.

Тийм учраас энэ хоёр хоорондоо айхтар зөрчилдөхгүй байх гэж бодож байна.

Хоёрдугаар асуултын хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, цэцэд маргаан хийж хянан шийдвэрлэх тухай хууль нийгмийн хөгжлөө дагаад хөгжиж байх ёстой. Цаашдаа таны дурдсан иргэдийн үндсэн эрхийн маргаан болон ер нь Монгол Улсад Үндсэн хуулийн түвшинд нь тунхаглалаа хамгаалсан олон асуудлуудыг Үндсэн хуулийн цэц хяналтдаа оруулж шийдвэрлэхэд цаашдаа Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргаад Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт орох нь зүй ёсны асуудал байх гэж бодож байна.

Б.Жавхлан: Тодруулж болно. Д.Энхтуяа гишүүний микрофоныг нээе. Тодруулга.

Д.Энхтуяа: Баярлалаа.

Тэгэхээр ер нь Үндсэн хуулийн цэцэд хамгийн тунгалаг хүмүүс очих ёстой гэсэн ийм үзэл баримтлал байдаг тэгээд хоёр хуульчдаа яг хувь хүний хувьд надад итгэхгүй байх тийм зүйл алга.

Гэхдээ Төрийн ордноос гарсан шийдвэр, бүх л бидний ярьж байгаа юм ард түмэн эсэргүүцээд байна л даа.

Тэгэхээр Та хоёр нэмэлтээр ийм асуултад хариулж өгөөч. Мэдээжийн хэрэг төрийн албанд ажиллахад бас л янз янзын л даваа гүвээг давж явдаг. Та хоёр хоёулаа асуудалд орж байсан. Ж.Сүхбаатар нэр дэвшигч сайд байхдаа ногоон

автобусны хэрэг гээд. Тийм ээ. Г.Эрдэнэбат нэр дэвшигч бол дэд прокурор байхдаа бас С.Зоригийн хэрэг гээд.

Тэгээд мэдээж хэрэг Та бүхэн бас энэ дээр өөрсдийнхөө хариултыг өгөөд, бид энэ асуудлаа цэгцэлсэн гэдгээ ард түмэндээ дуулгах, эсвэл цэгцрээгүй юм уу. Тийм ээ. Тэр мэдээллийг өгчихгүй юу.

Б.Жавхлан: Нэр дэвшигчийн микрофоныг нээе. Ж.Сүхбаатар нэр дэвшигчээс асуусан уу? Хоёулангаас нь асуусан уу? Ж.Сүхбаатар нэр дэвшигчээс эхэлье.

Ж.Сүхбаатар: Д.Энхтуяа гишүүнд их баярлалаа. Бас ингээд хэлэх боломж олдож байгаад.

Би Монголын төрд 20 гаруй жил ажилласан. Улсын Их Хуралд хоёр удаа сонгогдсон. Байнгын хорооны даргаар ажилласан. Олон хуулийг хийсэн. Парламентын хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч хийж, сонсголчуудын хамгийн анхны зам мөрийг нь татсан.

Манай Их Хурлын дарга байж байгаа. Манай Их Хурлын гишүүд энд бас байж байна. Бид хэд өмнө нь олон шинэчлэл, шүүхийн шинэчлэл хийсэн. Одоо сая шүүхийн шийдвэр ил тод нэвтэрдэг боллоо шүү дээ.

Тэгээд зүгээр яах вэ, яривал их олон юм бий. Зүгээр товчлоод хэлэх юм бол сая шүүх эрх мэдлийн үйл ажиллагаатай би биечилж танилцлаа. Сургамж ч авлаа.

Ер нь болсон процесс ярих юм бол хүн өөрийгөө өмөөрч ярихаар ямар нэгэн хэрэгт холбогдсон хүмүүсийнхээ эсрэг тэдэн рүү буруу чихэж байгаа юм шиг, эсвэл хамтран ажиллаж байсан удирдлага болсон улсуудынхаа эсрэг ярьж байгаа юм шиг болох гээд.

Тэгээд хүн өөрийгөө авч үлдэхийн тулд би өөртөө ёс зүйн нэг л юм ярьсан. Намайг энэ ардчилсан нийгэм учраас буруутгах нэг нь буруутгаг. Энэ чинь нээлттэй. Тэгэхдээ би шүүх дээр Үндсэн хуульд заасан гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг гэм буруутайд тооцож болохгүй гэдэг энэ зарчмаа бариад тэр хэлдэг ярьдаг газар нь юмаа яриад явсан. Яг одоо надтай холбоотой хэрэг маргааныг ямар нэгэн хүн сонирхож байгаа бол шүүхийн өөрийнх нь суваг дээр байгаа юм нь зуун хувь ил тод байж байгаа.

Ер нь цөөхөн улс төрчдийн хэрэг сүүлийн үед нэвтэрсэн байгаа. Тэр З.Энхболд, Б.Энх-Амгалан бид нар л байгаа байх. Бусад нь тэгж зуун хувь ингэж ил тод нэвтрээгүй. Тэгээд тэндээс хүмүүс харсан байх.

Тэгээд энд нэг зүйл байгаа. Өнөөдөр хожсон хүмүүс нь юу юм бэ гэхээр би үүнийг сайн дураараа тэр мөнгө цаастай. Уг нь их мөнгөнөөс хол явдаг байсан.

Тухайн үеийн Ерөнхий сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд, Хууль зүйн сайд нарын хүсэлтээр гэх үү ингээд Улаанбаатар хотод мөнгө авч өгөх гэж л миний нэр дээр тавьсан л эд байхгүй юу.

Яагаад вэ гэхээр илэн далангүй хэлэхэд над дээр тавих юм бол Их Хурал дээр надаас хүмүүс энэ мөнгийг хотоос холдуулж авч чадахгүй, тойрог руу шилжүүлж чадахгүй гэдэг ийм аргументээр л энэ шийдэгдсэн юм.

Түүнээс би яам байхгүй, аппарат байхгүй учраас. Уг нь миний гаргасан бодлого нийтийн тээвэр нэгдүгээрт буюу энэ ерөөсөө Их Хурал, Засгийн газар олон нийт анхаарахгүй, хотын удирдлага чардайгаад өөрөө чадахгүй болохоор нь үүнийг би нэгдүгээр бодлого юм байна гээд аминдаа дэмжүүлээд явсан.

Өнөөдөр намайг хэрэгт холбогдоод байгаа 175.0 тэрбум төгрөг чинь одоо энэ Yutong автобус болсон гадуур явж байгаа шүү дээ.

Дарханд явж байгаа 20 автобус гээд Улаанбаатарт дахиад явж байгаа 100 автобус чинь бүгд надад дээр яригдсан төсвийн багц гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр сайд түүнийг төсвийн багц дээр нь байсных нь төлөө гэм буруутайд шууд тооцож болохгүй шүү дээ. Одоо өнөөдөр олон сайд нар дээр зөрчлүүд гардаг.

Тэгэхээр шууд өөрөө гэмт хэрэг үйлдсэн үү гэдэг асуудал чинь гэмт хэргийн бүрэлдэхүүн байна уу гэдгээр шийдэгддэг.

Тэгэхээр яах вэ, тухайн үед сонгууль ойртсон байсан. Өвөр хоорондоо тэмцэлдэж байсан улсууд байсан. Гаднаас автобус нийлүүлэх гэж байсан талын нөхдүүдийн ажиллагаа байсан.

Яах вэ, үүнийг би нэг их олон юм яримгүй байгаа юм. Зүгээр өөрөө харж үүнийг давж туулж ингээд гурван шатны шүүхээр ороод ингээд гэм буруугүйд тооцогдсон. Тэгэхдээ гурван жил, гурван он дамжлаа. Тэгэхдээ шүүх эрх мэдлийн үйл ажиллагаатай нэлээн сайн танилцлаа.

Монгол Улсын систем дээр том төслүүдийг хэрэгжүүлэхэд хяналт, хариуцлагын тогтолцоо, гүйцэтгэлийн шатад үнэхээр хангалтгүй учраас эцсийн дүндээ хэн нэгэн дээд албан тушаалтай үүнийг үүрч таарч байгаа юм.

Тэгээд би үүнийг үүрэх тавилантай байсан ч гэсэн өнөөдөр нийтийн тээврийн салбар энэ түгжрэлийн асуудлаар ойлголтууд урагшилсан гэж бодож байгаа.

Өнөөдөр Улаанбаатар хотын хууль, нэгжийн хуулиудын би өөрөө ажлын хэсгийн ахлагч байсан. Зарим хүмүүс буруутгаж байгаа тэр олон хуулийн

түгжээсийг уг нь тайлсан хүн нь. Одоо би энэ нөхдүүдийнхээ хамт, манай өөдөөс зарж байгаа гишүүд байж байна. Бид хэд энэ хуулийг нь баталж гаргаж байсан байхгүй юу.

Тэгэхээр би танд сая хэлж байгаа юм бол хуулийн хувьд гэм буруугүй болж байгаа. Тэгэхдээ ёс зүйн хувьд би хариуцлагаа хүлээсэн шүү. Яагаад гэвэл тав дахь өдөр асуудал яригдангуут нэг дэх өдөр би ажлаа өгөөд чөлөөлөгдсөн юм. Огцроогүй. Чөлөөлөгдсөн. Түүнээс гадна шүүмжлэлийн тэр мөндөр бороог өөртөө хүлээж авч хүлээн зөвшөөрсөн.

Яагаад гэвэл Монголын төрийн сул дорой байдал гэдэг бол дандаа хэн нэгэн зугтаж болохгүй шүү дээ. Хэн нэгэн хүн буруутгагдах ёстой. Хэн нэгэн хүн шүүмжлэгдэх ёстой. Гагцхүү араас нь харамсалтай нь үүнийг засах ажлууд нь л сайн явах ёстой.

Тэгэхээр би энэ дээр уйлан дуугарах юм уу, гомдоллох, хэлмэгдлээ гэж хэлмээргүй байна. Энэ бол Монголын түүхэнд нэг кэйс болоод цаашдаа нийтийн тээврийн салбар нь урагшлаад хөгжөөд яваасай. Их Хурал нь хянаад. Тэгээд гэм буруугүй хэрэгсэхгүй болсон.

Тийм учраас би өнөөдөр төрийн албанд ажиллах Үндсэн хуулийнхаа эрхийг эдлээд нэр дэвшээд явж байгаа.

Тэгээд Та бүхэн маань бодож болгооно биз ээ.

Б.Жавхлан: Ганбатын Эрдэнэбат нэр дэвшигчийн микрофоныг нээе.

Г.Эрдэнэбат: Баярлалаа. Би ер нь хууль зүйн салбарт 32 жил ажилласан байна.

Тэгээд үндсэндээ хил дээр хилийн цэрэгт хууль сахиулагч ажил хийж байсан. Хэрэг шалгаж байсан. Өмгөөлөгч хийж байсан. Прокурор хийж байсан. Хуулийн сургуулийн багшаа ч эрүүгийн эрх зүйн чиглэлээр хийсэн.

Тэгээд сүүлийн 5 жилийн хугацаанд хууль тогтоох бодлого боловсруулах салбарын ажилд хоёрдугаар эгнээнд туслаад ажиллаж байна.

Тэгээд хэрэг шалгаж байсан. Тэгээд нэг хэрэг дээр асуудалд орсон. Энэ хэргийн асуудал сая Ж.Сүхбаатар нэр дэвшигчийнхээс ялгаатай нь ам нээвэл уушги нээгээд ярих гэхээр яриулдаггүй. Төрийн нууцад хамаарсан гээд. Тодорхой зөрчил дутагдлын асуудлыг нь ил гаргаж олон нийтийг шуугиулчихаад бүхэлд нь ил гаргаач гэхээр гаргадаггүй. Ингээд энэ асуудал болсон.

Гэхдээ үүнтэй холбоотой хууль зүйн хариуцлагаа хүлээхэд тухайн ажилд хайнга хандсан байна, эрсдэлтэй нөхцөл байдлыг тооцоололгүйгээр асуудал үүсгэсэн байна гэсэн ийм дүгнэлт хүлээж аваад. Тэгээд би хуульч хүн байж

шүүхийн шийдвэрийг хүндлэх ёстой. Түүн дээр ямар нэгэн өөрийгөө зөвтгөж юм ярихаасаа илүүтэйгээр тухайн асуудлыг хариуцдагаараа хариуцаад хариуцлагаа хүлээгээд дуусгасан.

Одоо ямар нэгэн байдлаар энэ томилгоотой холбоотой асуудал шийдэхэд хууль зүйн асуудал байхгүй.

Б.Жавхлан: Баярлалаа. Хоёр нэр нэр дэвшигчид. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Нэрээ өгөөрэй. Сархадын Зулпхар гишүүнээр тасаллаа.

Аюушийн Ариунзаяа гишүүний микрофоныг өгье.

А.Ариунзаяа: Жамъянхорлоогийн Сүхбаатар Америкийн Нэгдсэн Улс, Швед, Казахстан зэрэг сургуулиудад мэргэжил дээшлүүлж байсан, сургалтад хамрагдаж байсан, гадаад, дотоод нэлээд олон судалгаануудыг хийж байсан.

Төрийн албаар дийлэнхдээ явсан. Нам, төрийн албаар дийлэнхдээ явсан.

Ганбатын Эрдэнэбат Ерөнхийлөгчийн Тамгын газарт хуулийн асуудал хариуцаж байсан туслах. Улсын ерөнхий прокурорын газарт хэлтсийн даргаас эхлээд Ерөнхий прокурорын орлогчоор ч ажиллаж байсан.

2019-2022 онд Монголын криминологичдын холбооны ерөнхийлөгчөөр ч ажиллаж байсан.

Ийм хоёр хүн хоёулаа шударга бусын хонгилоор чирүүлсэн. Цэц өөрөө энэ хонгилын эд эс нь байх вий гэдгийг л өөрсдөө бодож, ийм асуудал улс төрийн шахаасаар орж ирэх вий гэдгээс та хэд маань одоо зүгээр.

Тэгэхээр одоо сүүлийн үеийн үйл явдлуудыг харж би энэ дүгнэлтийг хэлээд байгаа шүү дээ.

Тэгээд адилхан хүмүүсийг хонгилоор чирэхгүй байх тал дээр нь Та хоёр анхаарч ажиллаасай гэж чин сэтгэлээсээ хүсэж байна. Цэгцлээрэй. Цэцийн нэр хүндийг өсгөөрэй. Цэцийн шийдвэрээр ёс зүйгээр нь эгүүлэн татах асуудлыг хүртэл ярьж Улсын Их Хурлын чуулганы босгыг давсан хуулийн төсөл байгаа шүү.

Тэгээд ёс зүй гэж юу юм гэдгийг хүртэл та хэд өөрсдөө мэдэж байгаа байлгүй дээ. Хуульчдын хувьд энэ болох юм уу, болохгүй юм уу гэхчлэн цэц байх ёстой байр суурь дээрээ хатуу байгаарай гэж дахин дахин захъя. Протоколд үлдээе.

Б.Жавхлан: Сархадын Зулпхар гишүүний микрофоныг өгье.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Манай Төрийн байгуулалтын маш чухал бүрэлдэхүүн хэсэг болсон Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүйн салбарт мэргэшсэн улс төрийн болон төрийн ажлын туршлагатай хоёр нэр дэвшигч орж ирж байна.

Нэр дэвшигчдийн тухайд угаасаа мэргэжлийн болон ажлын туршлагын талаар ярих зүйл байхгүй. Бүгдээрээ л Та бүхэн эрхээ биш хүлээн зөвшөөрч байгаа байх.

Тэр битгий хэл бид Та бүхэнд Үндсэн хуулийн цэц дээр очоод яаж ажиллахыг ч гэсэн бас нэг айхтар хэлсэн хэлээгүй Та бүхэн тэрийг мэдэж ажиллах нь эргэлзээгүй.

Гэхдээ нэгэнтээ энэ хууль тогтоох институцийн хувьд тодорхой, жишээ нь институцийн томилгоотой холбоотой ийм хэлэлцүүлэг, ийм асуудал яригдаж байх үед бид бас саналаа хэлдэг. Та бүхэнд тодорхой зарим зарчмуудыг ажилдаа анхаараарай гэж сануулдаг.

Энэ бол Та бүхний мэдэж байгаа зүйлийг эргэн сануулж байгаа хэлбэр. Та бүхний ой санамжийг л дахиж сэргээж байгаа л хэлбэр гэж ойлгоорой гэж байгаа юм.

Би ийм 5 зарчмыг Та бүхэнд тэртээ тэргүй баримтална. Үүнийг баримтлаарай гэж албан ёсоор энд тэмдэглэж үлдээх бодолтой байна.

► **Нэг дэх нь,** Үндсэн хуулийн цэцийн гишүүн хараат бус байх ёстой.

Энэ бол нийгмийн өөрийнх нь хүлээлт. Улс төрийн үйл явц дахь маш чухал хүлээлт.

Та бүхэн аль ч намаас ямар нэгэн байдлаар хараат бус байдлаар үйл ажиллагаагаа цаашдаа явуулна гэдгээ өөрсдөө тангарагаа өргөх үедээ ч гэсэн үүнийг дотроо санаж, ажлаа хийж байхдаа үүнийг байнга санаж хийнэ гэдэгт эргэлзэхгүй байна.

Ингэж гэмээ нь улс төр дэх зарим нэг Үндсэн хуулийн цэц дээр очсон тодорхой маргаан гэдэг юм уу, тодорхой үнэн зөвийг олохтой холбоотой асуудал дээр та бүхний шийдвэр зөв байж таарна. Нийгэм өндөр хүлээлттэй байгаа.

Өнгөрсөн жил тойрны зарим нэг асуудлууд үүнийг илүү тодотгож өгч байгаа шүү гэдгийг онцлон тэмдэглэж байна.

► **Хоёр дахь нь,** Хууль дээдлэх.

Хуулийн өмнө, шүүхийн өмнө, цэцийн өмнө бүгд эрх тэгш байдаг.

Та бүхэн ч гэсэн хүн болгоныг эрх тэгш байгаа гэдгийг нь оролцогч тал болгоныг, төрийн институц болгоныг оролцох үед нь эрх тэгш байгаа шүү гэдэг талаас нь асуудалд хандана гэдэгт эргэлзэхгүй байна. Ингэж Та бүхэн чадна гэж бодож байна.

Энэ бол та бүхний үнэт зүйл, ажлын үндсэн баримтлах зарчмаас гадна байнга хэрэгжүүлэх ажлын арга зүй болгох ёстой гэж ойлгож байгаа.

- **Гурав дахь нь,** Үндсэн хуулийн цэцээс гарч байгаа шийдвэр дээр цэцийн гишүүн төвийг сахидаггүй. Ерөөсөө төвийг сахина гэсэн ойлголт байхгүй. Улс төрөөс ангид байдаг.

Тэгэхээр бид заримдаа төв ч бай, заримдаа төвийг сахисан шийдвэр гарга гэж улс төрийн түвшинд ярьдаг ч гэсэн яг энэ институц дээр ийм зүйл яригдахгүй. Та бүхний шийдвэр бол зөвхөн Үндсэн хуульд захирагдана. Зөвхөн Үндсэн хуульд захирагдана.

Тэгэхээр одоо гарч байгаа шийдвэр маань Үндсэн хуульд захирагдаж байгаа гэж бид ойлгож төрийн институцийн хувьд хүлээж авдаг. Цаашдаа та бүхний оролцож гаргах шийдвэр ч гэсэн тийм байгаасай гэж хүлээж байгаа шүү гэдгийг энд онцлон тэмдэглэж байна.

- **Дөрөв дахь нь,** Манай нийгмийн хамгийн том хүлээлт болсон Та бүхний хэрэгжүүлэх, Та бүхний институцийн хэрэгжүүлэх ажил шударга ёсны шалгуур, шударга ёсны зарчим.

Шударга ёс. Та бүхэн хэлж байна. Бидэн дээр зохих түвшинд бидний эрхийн асуудал. Бидэнд шударга бус байдал бий болсон гэдгийг биеэрээ туулсанаа хэлж байна. Энэ бол харамсалтай. Энэ бол манай шүүхэд байгаа магадгүй байгаа алдаануудын нэг. Үүнийг Та бүхэн өөрсдөө биеэрээ туулсан бол цаашдаа ийм зүйл байлгахгүйг цэцийн түвшинд Та бүхэн хийх ёстой.

Та бүхний гараа өргөж саналаа өгсөн цэцийн даргын алх цохиж шийдвэр гаргасан энэ зүйл дээрээс байнга гарч явах ёстой учраас үүнийг бид нийгмийн хүлээлт шүү гэж ойлгох ёстой. Улс төрийн хүрээний маш чухал хүлээлт байгаа шүү гэдгийг ойлгох ёстой.

- **Тав дахь нь,** бид бүгдээс Та бүхэн төрийн өндөр албан тушаалтан байсан. Төрийн өндөр албан тушаалтан болох энэ сонголт од орж байна. Энд сууж байгаа бид мөн адил төрийн өндөр албан тушаалтан. Бидний баримтлах хамгийн чухал зүйл бол ёс зүй.

Ёс зүй бол бүх зүйлийн хэмжүүр. Бүх харилцааны хэмжүүр. Ялангуяа албаны харилцааны суурь нь ёс зүй байдаг бол энэ ёс зүйн байдлыг төрийн өндөр

албан хаагчийн ёс зүйг Та бүхэн өндөрт өргөж үлгэр дуурайлал болж явах ёстой шүү гэж би ойлгож байна.

Би хувьдаа Та хоёрыг ажил хэргийнх нь байдлаар нь мэднэ. Бас мэдээж хэрэг янз янзын нийгэмд болж байгаа нөхцөл байдлыг бид янз янзаар ярьж болно. Нийгэм олон талт байдлаар ярьдаг. Гэхдээ та бүхнийг бид дэмжиж, саяын хэлсэн тэр шударга ёсыг тогтоох, эрх мэдлийг хэрэгжүүлэх институцийн бүрэн эрхт гишүүн байдлаар ажиллах нь ажиллуулах нь зүйтэй гэж ойлгож байна. Амжилт хүсье.

Б.Жавхлан: Лувсаннямын Гантөмөр гишүүний микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Хэдэн зүйл хэлье.

Ер нь Үндсэн хуулийн цэцэд итгэх бидний итгэл бүрэн алдарсан байгаа шүү. Цэцийн хуралдаж байгаа байдал, өргөдөл хүлээж авч байгаа байдал, тэрийгээ хэлэлцэж байгаа цаг хугацааны хуваарь, гаргаж байгаа шийдвэр гээд.

Тэгээд хүнээ байдаг. Тэгээд би Та хоёрт хэлэх юм бол тэр хуульч хүн гэдэг өөрсдийнхөө нэг олж авсан мэдлэг, тэр юмаа хамгаалж хүнээрээ байгаарай.

Тэгээд нэг байшин руу орохоороо хор найруулаад алга болцгоодог.

Тэгээд гарч байгаа шийдвэрүүд нь яг Их Хурлынхаа хууль тогтоох бүрэн эрх рүү халдаж эхэлдэг. Яг үнэндээ бид Монгол Улсын эрх мэдэлтэй хүмүүст зориулсан дэг журмыг Улсын Их Хурал тогтооно.

Тэгээд Их Хурлын баталсан хууль тогтоомжийн дагуу тогтож байгаа тэр дарга нарт зориулсан дэг журмыг та нар хүний эрх нэрээр будилуулж байгаа. Ялангуяа хамгийн сүүлд Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн хугацаан дээр ямар шийдвэр гаргав. Тэр чинь Их Хурал өөрөө мэдэж байна шүү дээ. Тэрийг. 6 жилийн хугацаатай, нэг удаа томилно. Энэ чинь Их Хурал мэддэг юмаа мэднэ.

Тийм учраас ийм улс төрийн захиалгатай, олигархуудын захиалгатай шийдвэрийг гаргахаас зайлсхийж яваарай гэж би хоёр нэр дэвшигчдэд хэлмээр байна. Тэгэхгүй бол Монгол Улсад итгэх газар үгүй болсон. Хэнд итгэхээ мэдэхээ больсон.

Тийм учраас хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэж ажиллана гэдэг бол яг цэцийн гишүүдэд зориулсан тийм зарчим шүү. Цэц бол яг энэ зарчмаар ажиллах хэрэгтэй.

Дээр нь Их Хурал яаралтай ажлын хэсэг гаргаж энэ цэцийн хуулийг шинэчлэх хэрэгтэй. Цэц ядаж тойрч суугаад мэтгэлцдэг талбар болох хэрэгтэй.

Цэц яахаараа Их Хурлын гишүүдтэй мэтгэлцээд сууж байдаг юм. Их Хурал нэг төлөөлөгч гээд. Өмнө нь баталсан хуулийн өмнөөс одоо бид нар яаж төлөөлөгч томилох юм. Мэдэхгүй байна. Одоо 7 жилийн өмнө хууль батлахад байсан хүн байгаа юм уу. Яаж өмнөөсөө нь очиж хууль тайлбарлах юм. Тэгээд тэрэнтэй мэтгэлцээд суугаад байгаа байхгүй юу. Хоорондоо мэтгэлцдэг болох ёстой. Тойрч сууж хуралддаг болох ёстой. Тэр хурлын протокол ил байх хэрэгтэй.

Өөрсдийнхөө итгэл үнэмшлийг тэнд хамгаалж ярилцаж байгаад олонхоороо шийдвэр гаргадаг зарчим руу явахгүй бол шүүх хурлын бүрэлдэхүүн шиг хохирогч, нэхэмжлэгч хоёр луу харж сууж байгаад тэр хоёрын зөв бурууг дэнсэлдэг ийм газар биш байна гэж би хувьдаа харж байгаа шүү.

Тийм учраас хурлын заалнаас нь эхлээд, хурлын хэлбэрээс нь эхлээд бид бол өөрчлөх зүйл олон байна. Олон байна.

Тэгэхээр хамгийн чухал юм одоо би чадна. Цэцэд очсон хүмүүсийг харахаар нэг бигээр өвчилсөн улсууд. Хэн юм бэ. Монголд хууль мэддэг аравхан хүнийг цэцэд томилсон юм шиг боддоггүй больцгоох хэрэгтэй.

Та хоёр ч гэсэн ялгаагүй. Би л хуулийн дээд оргил. Би л тэгэхэд тийм юм хийж байсан гэдэг ийм байдлаар асуудалд ерөөсөө хандаж болохгүй.

Хуулийн анхан шатны оюутны хэмжээний тийм сэтгэл зүрхтэй байж байж Монгол Улсад шударга ёс тогтоно. Монгол Улс эв нэгдэлтэй улс болно. Асуудал маш ойлгомжтой тайлбартай явдаг ийм зүйл рүү явмаар байгаа шүү.

Би тэгээд яагаад бухимдаж байгаа вэ гэхээр –

- Их Хурлын Сонгуулийн хуультай холбоотой цэц олон янзын шийдвэр гаргасан.
- Давхар дээл. Засгийн газрын гишүүдийн хэм хэмжээг тогтоосон хуулиудтай холбоотойгоор, дэг журамтай холбоотой олон шийдвэр гаргасан.
- Их Хуралтай холбоотой олон шийдвэр гаргасан.

Одоо цаашдаа прокурор. Прокурорыг одоо та нар удахгүй 6 жилээр нэг удаа биш зөндөө олон удаа томилдог байх ёстой гэдэг шийдвэр гаргахад их ойрхон ирлээ шүү дээ.

Гэх мэтчилэн том хүмүүст зориулсан шийдвэр лүү та хэд орохдоо улс төрийн захиалгатай ороод байгаа шүү. Энэ бүх хүнд ил байгаа шүү.

Тийм учраас Та хоёр анхнаасаа хичээж ажиллаарай гэдгийг чин сэтгэлээсээ хүсэх байна. Амжилт хүсье. Баярлалаа.

Б.Жавхлан: Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалтдаа бэлтгэнэ ээ. Гишүүд анхааралтай байгаарай. Төхөөрөмжөө идэвхжүүлээрэй. А.Ганбаатар гишүүн, Л.Гантөмөр гишүүн, Ц.Даваасүрэн гишүүн, Т.Доржханд гишүүн, Ч.Лодойсамбуу гишүүд төхөөрөмжөө идэвхжүүлээрэй.

Ц.Даваасүрэн гишүүн, Т.Доржханд гишүүн, Ч.Лодойсамбуу гишүүд төхөөрөмжөө идэвхжүүлээрэй. Санал хураалт.

Нэг.Улсын Их Хурлын даргаас Үндсэн хуулийн цэцийн гишүүн санал болгосон нэр дэвшигч Жамъянхорлоо овогтой Сүхбаатарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

21 гишүүн санал хураалтад оролцож, 18 гишүүн дэмжиж, 85.7 хувиар дэмжигдлээ.

Хоёр.Улсын Их Хурлын даргаас Үндсэн хуулийн цэцийн гишүүнд санал болгосон нэр дэвшигч Ганбат овогтой Эрдэнэбатыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 18 гишүүн дэмжиж, 85.7 хувиар санал дэмжигдлээ.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлсэн саналыг хэлэлцэж дууслаа.

Нэр дэвшигч нарт амжилт хүсье. /алга ташив/

Дараагийн асуудалдаа орно.

**Хоёр.Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар
хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг
чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо

хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

1.Засгийн газар 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай 129 дүгээр конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 42.9 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Уг нь гайгүй л байна даа. Ж.Батжаргал гишүүн.

2.Засгийн газар 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын аж үйлдвэр болон худалдаа дахь хөдөлмөрийн хяналтын тухай 81 дүгээр конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

42.9 хувиар. Уг нь Л.Гантөмөр гишүүн дэмжсэн байна.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал нарын 19 гишүүн 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

21 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 42.9 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

4.Санал хураалт. Энэ чинь нөгөө яаралтай горимоор хэлэлцэх эсэх нь Их Хурал дээр шийдэгдсэн учраас шаардлагагүй юм байна шүү дээ. Тийм ээ.

Дараагийн асуудалдаа оръё.

**Гурав.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл,
Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон
“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

/Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг,
санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлнэ.

Ажлын хэсэг ороорой. Нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна.

Ажлын хэсэг ороорой. Төсвийн ерөнхийлөн захирагч нар ороорой.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Ж.Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Н.Номтойбаяр Монгол Улсын Шадар сайд, Т.Доржханд Монгол Улсын Шадар сайд, З.Мэндсайхан Сангийн сайд, Л.Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга, С.Магнайсүрэн Монгол Улсын ерөнхий аудитор, А.Үйлстөгөлдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Б.Хулан Сангийн дэд сайд, Б.Анар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Батцэцэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга, Д.Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга, Т.Энхтүвшин Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх, Ц.Одхүү Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга, Н.Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Л.Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Гантуяа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Х.Баярмаа Үндэсний аудитын газрын Бодлого төлөвлөлт, инновацын газрын дарга, Д.Энхболд Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Нандинжаргал Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор, Цогтбаяр Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Эрдэнэцэцэг Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Энхбаатар Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Эрдэнэцогт Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Ариунболд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга, Ганбаатар Ёс зүйн хорооны ажлын албаны дарга, Мөнхоргил Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга, Ариунбуян Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Батжаргал Стандарт, хэмжил зүйн газрын дарга, Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга, Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, О.Хуягцогт Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, М.Санжаадорж сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын

дарга, Дэлгэржаргал Сангийн Яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Наранчимэг Эрдэнэс Монгол компанийн Эрсдэлийн удирдлага хяналтын газрын дарга, Даваадалай Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, Отгонжаргал Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны Санхүүгийн хэлтсийн дарга, Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Гантогтох Сангийн яамны өрийн удирдлагын хэлтсийн дарга, Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Бат-Эрдэнэ Санхүүгийн хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цэрэндэлгэр Эрдэнэс Монгол хязгаарлагдмал компанийн Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын Нэгдсэн бүртгэл, тайлагналын хэлтсийн менежер бөгөөд ерөнхий нягтлан бодогч, Мөнхбаяр Эрдэнэс Тавантолгой Компанийн ерөнхий нягтлан бодогч, Гэрэл Эрдэнэс Тавантолгой компанийн ахлах эдийн засагч, Анхзаяа Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн, Дэлгэрмаа Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн.

Сангийн сайд Загджавын Мэндсайханы микрофоныг нээе. Танилцуулга.

3.Мэндсайхан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын чуулганы 6 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан.

Нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 30 их наяд 303.2 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 33.7 хувь, нийт зарлага, цэвэр зээлийн дүн 31 их наяд 331 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34.8 хувьд тус тус хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 27.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь дотоодын нийт бүтээгдэхүүний 1.1 хувьтай тэнцэж байна.

Тайлан тоонд улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 18 их наяд 988 тэрбум төгрөгт хүрч, 95.9 хувийн хүү, биелэлттэй.

Нийт зарлага, цэвэр зээлийн дүн 20 их наяд 414.3 тэрбум төгрөг буюу 90.5 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан тус Байнгын хороонд харьяалагдах Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн нарийн бичгийн дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн дарга, Монгол Улсын Тэргүүн Шадар

сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Монгол Улсын Шадар сайд, Монгол Улсын Засгийн сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний хорооны даргын багцын 162 төсөвт байгууллага, 6 төсөл, сан, төрийн өмчийн 55 аж ахуйн нэгж, нийт 223 төсөвт байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Улсын төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирлагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 1 их наяд 131.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, үүнээс урсгал зардал 975.9 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 155.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд тус Байнгын хороонд харьяалагдах 6 төсвийн ерөнхийлөн захирагчийн 36 төсөл, арга хэмжээнд 221.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжиж, өгнө үү. Баярлалаа.

Б.Жавхлан: Сангийн сайдад баярлалаа.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна.

Индрийн микрофоныг өгье.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын банийн хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах 7 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын талаар тоймлон танилцуулъя.

Нэг.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 4 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт, харьяа нэг байгууллагад хязгаарлалттай дүгнэлтийг өгсөн байна.

Аудитаар нийт 0.7 тэрбум төгрөгийн 16 зөрчил илэрснээс 0.6 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 3 албан шаардлага хүргүүлж, 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж өгсөн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсвийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 0.7 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 3 төсөл, арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн нь бүрэн хэрэгжсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 352.1 сая төгрөгийн 5 зөрчил илрүүлснээс 5 зөвлөмж өгсөн. Биелэлт 80 хувьтай байна.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын дарга.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэсэн үе шатын аудитад хамруулсан.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 571.2 сая төгрөгийн 11 зөрчил илэрснээс 438.6 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 8 албан шаардлага хүргүүлж, 119.5 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч, 13.1 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлээ.

Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5.4 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 10 төсөл, арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн нь бүрэн хэрэгжсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 14.8 сая төгрөгийн 5 зөрчил илрүүлснээс 0.6 сая төгрөгийн нэг төлбөрийн акт тогтоож, 14.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөнөөс биелэлт 68.9 хувьтай байна.

Гурав.Монгол Улсын Ерөнхий сайд.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 52 байгууллагын санхүүгийн тайланд нэгтгэснээс 26 байгууллагад дүгнэлт

гаргаж, 25 байгууллагыг түүвэрт хамруулж, 1 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй, харьяа 21 байгууллагад өөрчлөлтгүй, 4 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 2 тэрбум төгрөгийн 141 зөрчил илэрснээс 0.04 тэрбум төгрөгийн 20 төлбөрийн акт тогтоож, 1.2 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 42 албан шаардлага хүргүүлж, 0.8 тэрбум төгрөгийн зөрчлийн 79 зөвлөмж өгсөн байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.4 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 1 төсөл, арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн нь бүрэн хэрэгжсэн байна.

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 1 албан шаардлага өгсөн нь биелсэн дүн мэдээтэй байна.

Дөрөв.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 44 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 19 байгууллагад дүгнэлт гаргаж, 24 байгууллагыг түүвэрт хамруулж, 1 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Эрдэнэс Монгол” компани, түүний хараат болон охин 21 төрийн өмчит хуулийн этгээдийн болон “Эрчист Монгол” компанийн санхүүгийн тайланг нэгтгэсэн.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 4 байгууллагад өөрчлөлтгүй, 14 байгууллагад хязгаарлалттай, 1 байгууллагад сөрөг дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 5.8 их наяд төгрөгийн 234 зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчилд 17 төлбөрийн акт тогтоож, 3.8 их наяд төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 109 албан шаардлага хүргүүлж, 2 их наяд төгрөгийн зөрчилд 103 зөвлөмж өгч, 10.2 тэрбум төгрөгийн зөрчилд албан тушаалтанд хариуцлага тооцуулах 7 албан шаардлага хүргүүлж, хууль хяналтын байгууллагад 4.8 тэрбум төгрөгийн 1 асуудлыг шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 44.6 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 17 төсөл, арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөснөөс 14.3 тэрбум

төгрөгийн гэрээний дүнтэй 12 төсөл, арга хэмжээ буюу 70.5 хувь нь тухайн онд бүрэн хэрэгжжээ.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөрчил илрүүлснээс 1 албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгсөн нь бүрэн биелсэн байна.

Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын асуудал эрхэлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 79 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 49 байгууллагад дүгнэлт гаргаж, 30 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 35 байгууллагад өөрчлөлтгүй, 14 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт тус тус өглөө.

Аудитаар 39.2 тэрбум төгрөгийн зөрчил илэрч, 0.4 тэрбум төгрөгийн зөрчилд 55 төлбөрийн акт тогтоож, 19.4 тэрбум төгрөгийн зөрчилд 94 албан шаардлага, 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлж, 19 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 116 зөвлөмж өгч, 0.4 тэрбум төгрөгийн 1 зөрчилтэй асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүллээ.

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 56.1 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 36 төсөл, арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөснөөс 43.7 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 35 төсөл, арга хэмжээ буюу 97.2 хувь нь тухайн онд бүрэн хэрэгжсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид нийт 97.1 тэрбум төгрөгийн 13 зөрчил илрүүлснээс 37.1 төгрөгийн 9 албан шаардлага хүргүүлж, 60 тэрбум төгрөгийн 4 зөвлөмж өгснөөс биелэлт 77.8 хувьтай байна.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснийг түүвэрт хамрууллаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 25.5 сая төгрөгийн 2 зөрчил илэрсэн нь давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж бүрэн биелсэн байна.

Төрийн албаны зөвлөлийн дарга.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэний түүвэрт хамрууллаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 29.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Өмнөх аудитаар 631.1 сая төгрөгийн 9 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Дээр дурдсан аудитын дунд дүгнэлтээс үндэслэн дараах асуудлууд анхаарал хандуулах шаардлагатай гэж үзлээ.

1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийн саналыг боловсруулахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцүүлж, тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, түүнд шаардлагатай төсвийг үнэн зөв бодитой тооцоолох.

2.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, бүртгэх, үр дүнг үнэлэх үе шат бүрд төсвийн ерөнхийлөн захирагч болон оролцогч байгууллага, албан тушаалтнуудын хяналт, хариуцлагыг сайжруулах.

3.Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн байдлын тайлан дахь бусад эргэлтийн хөрөнгө, дансан дахь хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон ашиглалтад орсон хөрөнгийг ашиглаж ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, ажлын гүйцэтгэл санхүүжилтийг үе шат бүрээр бүртгээгүй зэрэг зөрчил илэрч байгаад дүн шинжилгээ хийж эрх бүхий төрийн байгууллагуудад асуудлыг шийдвэрлэх талаар үүрэг чиглэл өгч ажиллах.

4.Монгол Улсын Засгийн газраас төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагаа, өр төлбөр, зээлийн зарцуулалт эргэн төлөлтийн гүйцэтгэлд хяналт тавих, үр ашгийг тооцдог, ил тод, хариуцлагатай байх тогтолцоог төлөвшүүлэх.

Эцэст нь төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд анхаарч, аудитын шийдвэр болон хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаад дүн шинжилгээ хийж, цаашид гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, төсөв санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх талаар холбогдох байгууллагад чиглэл өгч, төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн

заалтын хэрэгжилтийг бүрэн хангаж, дотоод хяналтын тогтолцоог сайжруулж ажиллах шаардлагатай гэж үзлээ. Танилцуулж дууслаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Жавхлан: Монгол Улсын ерөнхий аудиторт баярлалаа.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх Сангийн сайдын танилцуулга болон аудитын тайлан, Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүд байна уу?

Б.Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүний микрофоныг.

А.Ариунзаяа: Нэгдүгээрт, би ер нь чин сэтгэлээсээ юу гэж боддог вэ гэхээр энэ олон төрийн албан хаагчид, Засгийн газрыг ажлыг нь хийлгэх юмсан гэж боддог.

Төрийн ордонд өдөржингөө өнжөөд л, Байнгын хороод дамжаад л хүлээгээд л суух юм. Ярьж байгаа юмнууд нь дандаа ижилхэн.

Тэгээд л гишүүд нь ч юмаа уншихгүй, асуулт асуухдаа нөгөө л юмаа асуудаг.

Тэгээд бидний бүтээлч байдалд ер нь нэг дүн шинжилгээ хийхгүй бол. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайлан, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нэг жилийн хөгжлийн бодлогын тайлан, дунд хугацааны хөгжлийн бодлогын тайлан, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг бүр жилд хоёр удаа. Тэгээд нөгөө төлөвлөгөөгөө батлуулах гэж. Ингээд тувтан чуулганы хуралдааны гуравхан сарын дотор ёстой дандаа энд л уяатай.

Тэгээд яг үр дүн юу юм бэ гэдгийгээ бас нэг хармаар байгаа байхгүй юу. Энэ хүмүүс чинь хэзээ ажлаа хийх юм бэ гэдгийг би үнэхээрийн гайхаж байгаа юм. Ямар ч үр дүнгүй. Тэгээд төсвийн, санхүүгийн тайланг Төсвийн байнгын хороогоор хэлэлцээд явчхаж болдоггүй юм уу? Заавал бүх Байнгын хороогоор ороод л, тэгээд л хэрэгтэй хэрэггүй, ямар ч үр дүнгүй ийм ажил хийгээд байгааг нэг хармаар байна.

Тэгээд үүнийг хэн эргэж харах вэ? Засгийн газар өөрөө яг юу тулгамдаад байна вэ? Орж ирж байгаа хүн болгоныхоо ажлын байрны зургийг нь аваад үр дүнтэй байна уу, үгүй юу гэдгийгээ нэг хармаар байна шүү дээ.

Хайран цаг хугацаа. Улс орны хөгжилд үнэхээрийн энэ нэг үр бүтээлгүй явж байгаа энэ цаг хугацаа үнэхээр хайран.

Тэгээд хяналт шалгалтын хуулиа одоо эргэж харах ёстой юм уу, яах ёстой юм? Энэ олон давхардсан тайлан төлөвлөгөө, гүйцэтгэл үнэхээрийн бүр өөрсдөө ч ёстой нээрээ сайд нар нь юмаа мэдэхгүй. Ер нь энэ дээр нэг дүгнэлт хийхгүй болохгүй байна. Улсын Их Хурлын дарга аа.

Энэ дээр нэг анхаарч. Та ч өмнө нь сайдаар ч олон ажилласан, Хэрэг эрхлэхийн сайдаар ч ажилласан. Энэ төрийн албан хаагчдыг ажлыг нь хийлгэдэг байхгүй үнэхээрийн бүр залхмаар байна шүү.

Анхаарах ёстой энэ нэг санхүүгийн тайлан дээр нэгэнтээ л асуудал байгаа юм чинь. Энэ хар даа. Төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудад ашиглаж буй нягтлан бодох бүртгэлийн программ хангамж нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын өөрчлөлт шинэчлэл холбогдох журам зааврын дагуу шинэчлэгдээгүй байна, хяналтгүй байна, тайланд зөрүү үүсэж байна гэх зэрэг ийм асуудлыг одоо тэгээд бүх Байнгын хороодоор хэлэлцээд явж байгаа нь үнэхээрийн бас инээдэмтэй байна шүү. Бас арай ч дээ.

Нягтлан бодох бүртгэлийнхээ программыг тэр одоо гадаад өр, зээллэгээ хэрхэн яаж ашиглаж байгаа вэ гэдгийгээ ч гэсэн бүртгэж чадахгүй бид чинь сая 2 төслийг яаж нүдээ аньж энэ төсвийн гадуур гаргалаа.

Нэг ноцтой асуудал байгаад байна. Сангийн сайд аа. Төсвийн зарлагын эх үүсвэрийг нөхөж өглөг үүсгэсэн дүн гээд яригдаад байгаа байхгүй юу.

Төрийн сан дээр байгаа бусад сайд нарын багцын асуудлыг ашиглаад тэгээд өглөгийн дүнгээр бүртгээд яваад байна. Энэ асуудлаа нэг анхаараарай. Төрийн сан чинь үүнээс болж асуудалд үүсэх вий. Одоо би бүр гүнзгийрүүлж олон юм яримааргүй байна. Гэхдээ энэ дээр анхаараасай л гэж хүсэж байна даа. Миний хүсэлтийг хүлээж аваасай. Үнэхээрийн төрийн алба хийх ёстой ажлаа хийгээсэй.

Б.Жавхлан: Сангийн яам хариулах юм уу? О.Хувьцогт. Тэр төрийн сантай холбоотой юу юу гэнэ вэ? Тэрийг мэдээлэл өг дөө. Тийм өглөг гэж ямар юм байдаг юм? Аан? О.Хуягцогт. Би асууя.

Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогтын микрофоныг. Индэр дээрээс юм байна.

О.Хуягцогт: Сангийн яамны Төрийн сангийн газар. О.Хуягцогт А.Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газраас ер нь Засгийн газрын санхүүгийн тайлан дээр улсын төсвийн дансны өглөг үүсгэсэн дүн өмнөх оны дүнгээс 193.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна гэсэн ийм асуудлыг тавьсан.

Тэгээд энэ өмнөх он дээр энэ өглөг үүсгэсэн дүн нь 5 их наяд орчим төгрөг байсан. Тэгэхдээ төрийн сангийн нэгдсэн тогтолцооны хүрээнд энэ бол мөнгөн удирдлагыг Засгийн газраас, тэр тусмаа Сангийн яамны Төрийн сангаас хэрэгжүүлэх ийм хуулийн зохицуулалттай. Тэр хүрээнд хийгдсэн ажлууд.

Цаашид энэ төсвийн гүйцэтгэл, мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах замаар суурь тэнцлээ ашигтай гаргаж, энэ мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг үе шаттай бууруулах гэсэн ийм зөвлөмж, албан шаардлагыг өмнөх жилүүдэд өгсөн.

Үүнийг цаашаа зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж ажиллах чиглэлтэй байгаа.

Б.Жавхлан: Шал буруу тайлбарлаад байх юм. Н.Мөнхсүх дарга байна уу? Н.Мөнхсүх дарга чинь байхгүй юм уу? Чи өөрөө шал буруу хариулах юм.

Ч.Ундрам гишүүний микрофоныг нээе.

Ч.Ундрам: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Улсын төлөвлөгөө, төсвийн тухай хууль өөрөө сайн байж төсвийн гүйцэтгэл сайн байх үндсийг тавих байх гэж бодож байна.

Тэгээд бид ер нь энэ төлөвлөлтөө, төсвийн тухай хуулиа л нэг аятайхан хийж чадахгүй байгаа юм шиг надад санагдаад байгаа юм. Зарим хөрөнгө оруулалтын ажлыг хоёроос гурван жил хувааж тавьдаг. Энэ явцад юмны үнэ өсдөг.

Тэгээд л барилгын компаниуд нь төсөвт өртгөө нэмэгдүүлээд л, зарим нь бүүр хоёр, гурав дахин нэмэгддэг.

Тэгээд л үлдсэн мөнгө нь хаанаас гарах вэ, яах вэ гээд ажил гацах асуудал гардаг. Энэ дээр яаж сайжруулалт хийнэ гэж төлөвлөж байна вэ? Сангийн яам. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, өнгөрсөн жил ажил нь хийгдсэн мөртлөө санхүүжилтээ авч чадаагүй компаниуд байна. Одоо жишээлэх юм бол би өчигдөр Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоноос ирлээ. Тийшээ тавьж байгаа замын хөрөнгө оруулалтын ажил. Өнгөрсөн жил ажлаа хийсэн. Бүх материалаа бүрдүүлээд Сангийн яаманд өгсөн. Санхүүжилтийг нь хийгээгүй.

Тэгээд төсвийн жил дуусчхаж байгаа юм. Одоо энэ жил рүү үлдэгдэл ажлаа хийгээд, үлдэгдэл санхүүжилтээ авах ёстой байтал. Гэтэл өнгөрсөн жилийн ажлын санхүүжилтийг энэ жилийн төсвөөс олгох ийм жишээтэй.

Тэгээд нөгөө компани нь үргэлжлүүлж ажлаа хийх юм уу, яах юм бүү мэд. Иймэрхүү ажлууд зөндөө байна. Ийм асуудлууд. Үүнийг яаж шийдэх юм бэ? Сангийн яам.

Худалдан авах ажиллагаа удаан байна. Үүнээс болоод маш олон сургууль, эмнэлгүүд төсөвт хөрөнгө мөнгө нь шийдэгдсэн байсан боловчиг янз бүрийн асуудал болоод ингээд 6 сарын 01-нээр хаагдаад. Тэгээд энэ ажлуудыг хийх ямар ч боломжгүй болсон.

Тэгээд өчнөөн Монгол Улс чинь сургуулийн асуудал, эмнэлгийн асуудал байгаад байдаг. Үүнийг бараг Сангийн яам далимдуулаад бушуухан цуцалъя гээд ингэххэж байгаа байхгүй юу.

Тэгээд энэ жил барьж чадаагүй. Төсөвт уг нь мөнгө нь тавигдсан байсан ажлууд чинь ирэх жил төсөвт өртөг нь өсөөд л явна шүү дээ. Үүнийг ер нь бид яаж шийдэх ёстой юм. Энэ сургууль, эмнэлгүүдээ хоцорсон ч гэсэн бид тендерээ зарлаад хөрөнгө оруулалтаа хийгээд явж болдоггүй юм уу? Өчнөөн хүүхдүүд сургуульд хоёр ээлж, гурван ээлжээрээ элдээд байна гээд л яриад байдаг. “Боловсролын жил” болгоё гээд л Сангийн яамнаас зарлаад байдаг.

Тэгээд та хэдийн хариуцлагагүй удаан байснаас болоод бид сургуулиа нэмж барих ямар ч боломжгүй болоод байна. Энэ дээр хариулт авъя.

Б.Жавхлан: Сангийн сайдын микрофоныг өгье.

3.Мэндсайхан: Ч.Ундрам гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр Сангийн яамны хариуцлагагүй байдлаас 6 сарын 01-нээр төсөл хөтөлбөрүүд гацаад байгаа асуудал огт байхгүй.

Хэмнэлтийн хуулиараа 6 сарын 01-нээр тасалбар олгоод тус хугацаанд тендер, сонгон шалгаруулалтаа зарлаад гэрээ байгуулсан тохиолдолд энэ ажлууд үргэлжлээд явж байгаа.

Улсын төсөв бол тухайн оныхоо 11 сарын 15-нд батлагдаж байгаа. Үүнээс хойшоо бэлтгэл ажлаа хангаад 6 сарын 01 хүрэх хугацаанд хангалттай хугацаа байгаа. Энэ хугацаанд гэрээ байгуулсан ажлуудыг л бид хуулийн дагуу үргэлжлүүлээд явж байгаа. Энэ хугацаандаа гэрээгээ байгуулаагүй ажлууд хуулийн дагуу татагдаад явж байгаа.

Тэр Буганттай холбоотой асуудлыг нь Ж.Дэлгэржаргал хариулчих.

Ж.Дэлгэржаргал: Ч.Ундрам гишүүний асуултад хариулъя.

Сангийн яам Ж.Дэлгэржаргал.

Өнгөрсөн оны хувьд нийтдээ бид 2.9 их наядыг олгохоор хөрөнгө оруулалт батлагдсанаас 2.1-ийг бүрэн олгосон. Үүн дотроо жилийн эцэст гүйцэтгэл нь ирсэн. Тэр дундаа 2025 онд дуусах төслүүдийг бүрэн олгоод, 2026 онд шилжин хэрэгжиж байгаа буюу 2026 оны санхүүжилт нь батлагдсан төслүүдийг гүйцэтгэлийг нь тасалдуулахгүйн тулд шилжүүлээд энэ оноос нь олгоод явж байгаа гэсэн үг.

Тэгэхээр нэг талдаа бид санхүүжилтийн зохицуулалт хийгээд явж байгаа.

Тэгэхээр нийтдээ жилийн эцэст ирээгүй 779 бол яг гэрээтэй төслүүдийн үлдэгдэл байгаа учраас бид 2027 оны төсөвтөө үүнийг нь гүйцээгээд тусгаад ингээд явна.

Төсвийн хууль дээр 3 хүртэлх жилд хэрэгжүүлнэ гэж байгаа. Хамгийн ихдээ 3 жил, хамгийн багадаа 1 жил байж болно.

Тэгээд ер нь 5 сарын 31-нээс хойш тендерийн үйл ажиллагаа дуусаж байгаа учраас гүйцэтгэлээ бүрэн шахаад гаргах боломж нь захиалагч болон гүйцэтгэгчид бүрэн байгаа.

Б.Жавхлан: Ч.Ундрам гишүүн тодруулъя.

Ч.Ундрам: Би танай кабинетаас асуулт асуугаад байгаа юм л даа.

Энэ тендерээ та хэд бүхэл бүтэн хагас жилийн хугацаанд зарлаад, худалдан авалтаа хийж чадахгүй, үүнээс чинь болоод ард иргэд, хүүхдүүд хохироод байна гэж байгаа юм. Би түүнээсээ Сангийн сайд таныг буруутгах гээд ингээд байгаа юм биш.

Энэ тендерээ цагт нь бүтэн хагас жилийн хугацаанд бушуухан зарлаад энэ хүүхдүүд, ард иргэдийг хохиролгүй болгоод өгөх ёстой байхгүй юу.

Улсын Их Хурлын гишүүд ажлаа хийгээд, төсвийг чинь батлаад өглөө. Өмнөх жилийн 11 сарын 15 гэхэд батлаад өглөө. Үүнээс хойш хэр хугацаанд тендер зарлаж амжих юм бэ? Та нар. Бүхэл бүтэн хагас жил болж байна шүү дээ. Бараг 7 сарын хугацаанд зарлаж чадахгүй. Ингээд өчнөөн сургуулиуд баригдаж чадахгүй. Багш нар нь, захирлууд нь над руу яриад байгаа байхгүй юу. Сэлэнгэ аймгаас авхуулаад л ер нь энд тэндээс

Тэгэхээр үүнийгээ нэг цаг хугацаанд нь яавал хийж чаддаг болох юм бэ? Т.Доржханд сайд аа.

Б.Жавхлан: Т.Доржханд сайдын микрофоныг өгье. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар.

Т.Доржханд: Зөв зөв. Асуулт бол зөв. Тэгэхдээ яг бодит байдлаа бүгдээрээ ярих ёстой байх.

2025 оны төсвийн гүйцэтгэл ярьж байгаа. Тийм ээ. Тэгээд 2025 оны төсөв маань өөрөө батлагдахдаа хоёр удаа хойшилж батлагдсан. Хугацаа тулсан. Бодит байдал нь. Нэг.

Хоёрдугаарт, яагаад 5 сарын 31-ндээ багтдаггүй юм бэ гэхээр зураг төсөв нь л ирдэггүй шүү дээ. Ажлын даалгавар нь ирдэггүй. Гишүүд тойрогтоо маш их хэмжээний төсөл, арга хэмжээ тавьдаг. Тэгээд төсвөө батлуулаад л орхидог. Араас нь ажлын даалгавар, зураг төсөл нь ирэхгүй болохоор чинь тендер амжилтгүй болох нөхцөл нь үүсэж байгаа байхгүй юу.

Гэхдээ бас бодитой мэдээллийг бодитоор нь өгье. 2025 оноос өмнө 2 тендерийн худалдан авах ажиллагааны 1 нь амжилтгүй болдог байсан юм билээ. Хууль шүүхийн байгууллагаар явдаг байсан.

Тэгвэл 2025 оны гүйцэтгэлээр 85 хувьтай гарсан. Бид ирсэн зураг төслийн хүрээнд 100 хувь худалдан авах ажиллагааг нь зохион байгуулсан. Харин энэ дотор гэрээ байгуулсан нь 85.1 хувьтай. Тэгээд тендер дээр бас гомдол гардаг. Гомдол гараад 10 өрсөлдөгч орлоо гэхэд 1 нь шалгардаг, 9 нь гомддог. Үүнээс болоод хугацаа алдаг зүйл байгаа.

Харин Ч.Ундрэм гишүүний хэлээд байгаа барилгын ажил дээр 5 сарын 31-нээр байж болно. Харин тоног төхөөрөмж дээр заавал 5 сарын 31 гэж тавих шаардлага байна уу, үгүй юу гэдэг дээр би санал нэг байгаа.

Сургууль нь 9 сарын 01-нд. Барилгын ажил нь баригдлаа. Тэрний дараа нь тоног төхөөрөмжийн худалдан авалтыг заавал хэмнэлтийн хуульд ороод хязгаарлахаар яг түрүүчийн асуудал үүсээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал биш шүү. Тэгвэл хэмнэлтийнхээ хууль дээр бараа, тоног төхөөрөмжийг... /минут дуусав/

Б.Жавхлан: Ч.Ундрэм гишүүн тодруулъя.

Ч.Ундрэм: Энэ Хэмнэлтийн тухай хууль, тэгээд Худалдан авах ажиллагааны тухай хуулиас болоод энэ асуудлууд гарч байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнийгээ сайжруулах, энэ хуулиа сайжруулах ажлаа та хэд хийдэггүй юм уу? Та ялангуяа хариуцсан сайд нь шүү дээ.

Б.Жавхлан: Т.Доржханд гишүүний микрофоныг нээе.

Т.Доржханд: Хуулийн төслүүдийг 2024 онд боловсруулаад өгсөн шүү дээ. Тэгээд Засгаас өргөн барья гэсэн. Засгаас барих нь зохимжгүй юм байна. Гишүүдээс өргөн барья гээд. Тэгээд гишүүдэд өгсөн.

Тэгээд л энэ чинь баахан л бужигнаан боллоо шүү дээ. Хамгийн түрүүнд бэлдээд өгсөн. Одоо ингээд П.Сайнзориг нарын гишүүд хуулийн нэмэлт, өөрчлөлт хийж байгаа. Тэгэхдээ энэ асуудал хуульдаа биш шүү. Дахиад хэлье. Бүх ажлыг 100 хувь гүйцэтгэлтэйгээр манайх ирсэн зураг төслийнх нь хүрээнд зохион байгуулаад тэгээд гэрээг байгуулах ажлыг нь хийж байгаа шүү дээ. Энэ чинь.

Ганцхан асуудал нь юу байна гэхээр тэр зураг төсөл чинь байхгүй байгаад байна шүү дээ. Ажлын даалгавар чинь ирэхгүй байна шүү дээ. Тэрийг чинь зохион байгуулж байгаа хүмүүс санаанаасаа зохиож зурж болохгүй байхгүй юу.

Техникийн тодорхойлолтыг ирэх ёстой. Байшин барилаа гэхэд ямар стандарттай байх ёстой юм. Мэргэжлийн байгууллагуудаас нь ирэх ёстой. Орон нутагт хийж байгаа тэр худалдан авах ажиллагаанууд чинь орон нутгаасаа ажлын даалгавар, зураг төсөл нь ирэх ёстой. Тэд нар маань ирэхгүй байна шүү дээ.

Тийм болохоор манай гишүүд төсөв тавихдаа тавьж болно. Хажуугаар нь араас зураг төсвөө хий гэсэн ийм байдлаар та нар шахаж явах ёстой шүү.

Хоёрдугаарт, хууль өргөн барихад бэлэн болсон байгаа. Хууль дээр та нар өөрсдөө саналаа өгөөд явахад бүрэн боломжтой шүү.

Тэгээд төсвийн хэмнэлтийн хууль дээр саяын заалтуудыг хасах юм бол энэ урсгал ажлууд чинь хийгдэх бүрэн боломжтой. Төсвийн хэмнэлтийн хууль чинь 2025 оноос л хийгдээд явж байгаа. Тэгээд үнэн. Ажлаа амжихгүй бол төсөв талдаа хэмнэлт болж байгаа ч гэлээ гэсэн нөгөө талдаа бол энэ хэмнэлтээсээ болоод худалдан авах ажиллагааны хууль нь буруу байна, худалдан авах ажиллагаа хийгдэхгүй байна гэх юм бол энэ бодит байдалдаа нийцэхгүй. Тийм.

Б.Жавхлан: Т.Доржханд гишүүн би танд их чухал юм хэлье.

Миний хэлээд байсан зүйл чинь одоо яг энэ дээр гарч ирж байгаа байхгүй юу.

9 сарын 01-нд өргөн барьсан Засгийн газрын төсөв 11 сарын 15-нд батлагдахдаа юу юу нь өөрчлөгдөв, сайжрав уу, муудав уу гэдгийг тогтоохын тулд батлагдсан төсвөө дахиад аудитлуулах хэрэгтэй.

Дахиад аудитлуулах ёстой байхгүй юу. Хэдэн ширхэг хөрөнгө оруулалтууд орж ирсэн, санал Засгийн газар бэлтгэж оруулсан. Тэр нь хэдэн зураг төсөвтэй байсан. Батлагдаад хууль гарахад Улсын Их Хурал дээр нэмэгдсэн худалдан авалтууд, хөрөнгө оруулалтууд дотор хэдэн зураг төсөвгүй, бэлтгэл ажил

хангагдаагүй, газар, дэд бүтэц нь байхгүй, тендер зарлах боломжгүй ийм төслүүд батлагдав гэдгийгээ зарлах ёстой байхгүй юу.

Тэгэхгүй энэ 5 сарын 31-нд чинь яг ийм асуудал гарч ирээд байгаа байхгүй юу. 5 сарын 31-нд татагдаж байгаа хөрөнгө оруулалтууд чинь бараг 90 хувь нь Улсын Их Хурал дээр нэмж батлагдсан хөрөнгө оруулалтууд байгаа. Тэрийг нь зарлах ёстой байхгүй юу.

Улсын Их Хурал дээр тэр тэр гишүүний саналаар ийм ийм зураг нь байхгүй, бэлтгэл ажил нь хангагдаагүй ийм хөрөнгө оруулалтууд нэмэгдсэн. Үүнийг төрийн худалдан авах ажиллагаа шууд зарлах боломжгүй байсан учраас бэлтгэл ажлаа хангах гэж тэдэн сар боллоо. Ингээд амжсангүй. Ингээд татагдлаа гэдгийгээ тайлагнаж байх ёстой байхгүй юу.

Түүнээс биш зураг төсөв нь бэлэн, шууд зарлахад бэлэн тендерүүд 11 сарын 16-нд зарлахад бэлэн байдаг шүү. Энэ ялгааг оруулах хэрэгтэй. Үүнийг бас хуульчилдаг ч юм уу, яадаг юм. 9 сарын 01-нд тэртээ тэргүй өргөн барьсныг аудиталж байгаа юм чинь баталсныг нь бас аудиталдаг байх хэрэгтэй. Муудширсан уу, сайжирсан уу. Тийм. Үүнийг хийх ёстой шүү.

Тэр 3 жилийгээ Ж.Дэлгэржаргал дарга жоохон дутуу тайлбарла шиг болох юм.

Энэ 2023 онд орсон өөрчлөлт юм. 2023 он хүртэл 3 жил битгий хэл бүр хязгааргүй байсан юм. Хэдэн жил ч явж болдог. 10 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт орж ирэхэд 100-хан сая төгрөг тавиад амсуулаад төслийг эхлүүлдэг. Тийм байсныг нь 3 жил гэж ядаж хязгаарлаад ингэж орж ирсэн байхгүй юу.

Түүнээс биш нэг жил байгуулах бол төслийг 3 жил болгох гээд хуваагаад тавьдаг юм биш. Хязгааргүй байсныг 3 жил гэж хязгаартай бас ингээд нэг цэгцтэй болгож ийм заалт орж ирсэн юм.

Тэр 5 сарын 31 энэ хоног бол буруугүй шүү.

Тийм учраас Улсын Их Хурал дээр батлагдахдаа ямар төсөв хөрөнгө оруулалттай батлах гэж байна вэ гэдгийг энд Улсын Их Хурлын гишүүд бид өөрсдөө төсвөө батлахдаа үүнийгээ бодож батлах ёстой.

Б.Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Л.Цэдэвсүрэн дарга байгаа юм байна.

Тэгэхээр би нэг хууль бус үйл ажиллагааны талаар ярья гэж бодож байна.

Би энэ Булган аймгийн засаг дарга Д.Пүрэв-Очирыг хууль бусаар томилогдсон гэж Их Хурал дээр үг хэлсний төлөө намайг Ёс зүйн хороонд өгсөн.

Гэвч тэр асуудал маань одоо хүртэл алга болсон байгаа. Яасан ийсэн нь мэдэгдэхгүй.

Засаг дарга хүн бол төрийн албан хаагч байх ёстой.

Тэгэхээр төрийн албаны тухай хуулиар төрийн албан хаагч гэж хэн бэ гэдгийг бас танд хэлж өгье л дөө. Та өөрөө сайн тэрийгээ сахихгүй байх шиг байна.

3.1.2 дээр төрийн албан хаагч гэж төрийн албаны тушаалыг эрхэлж эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг. 4.7 дээр төрийн албан хаагчийн цалин хөлс, албан тушаалын цалингийн хэмжээ сүлжээг энэ хуулийн 9.2-т нийцүүлэн энэ хуульд заасан журмаар тогтоогоод, тэгээд Засгийн газар энэ асуудлуудыг бүгдийг нь шийдвэрлэдэг.

Гэтэл Д.Пүрэв-Очир гэдэг хүн Засаг даргаар томилогдохдоо төрийн албаны шалгуур хангасан юм уу гэдэг ийм тодорхойлолтыг та гаргаж өгдөг. Гэвч энэ хүн танд гаргаж өгсөн тодорхойлолт дээрээ Иргэний нисэхийн ерөнхий газрын Санхүүгийн газрын дарга гээд өгсөн байгаа. Гэтэл энэ хүн хэзээ ч тэр газар ажиллаж байгаагүй.

Энэ хүн ийм зузаан хөдөлмөрийн гэрээгээр, хамтын гэрээгээр, аль эсвэл одоо хөдөлмөрийн дотоод журамд заагдсаны дагуу хөдөлмөрийн гэрээгээр л ер нь бүгдээрээ ажилласан ийм олон гэрээнүүд байна.

Нэг ч төрийн албан хаагч ерөөсөө хийж үзээгүй хүнийг та 3 жил төрийн албан хаагч хийсэн гэдэг тодорхойлолт гаргаж өгөөд, түүнийх нь дагуу нөгөө этгээд нь Булган аймгийн Засаг даргад нэр дэвшихдээ Булган аймгийн иргэдийн Хуралд 2018-2022 онд Иргэний нисэхийн ерөнхий газар Нисэх буудлуудын удирдах газрын Бодлого, төлөвлөлт хариуцсан ерөнхий менежер гээд. Нөгөөдхөөсөө шал ондоо юм гаргаж өгөөд. Тэгээд сонгогдоод энэ хүн ажиллаад байгаа юм.

Анхнаас нь буруу замыг нь засаад өгсөн. Та албан тушаалтнуудын нөлөөнд орсон. Та хуйвалдсан.

Тийм учраас ийм тодорхойлолт гаргаж өгөөд, тэрнээс нь цаашаа үргэлжлээд энэ хууль бус үйл ажиллагаа өнөөдрийг хүртэл явж байгаа.

Тэгээд надтай оролддог нь яах вэ, дээ. Тэгээд Их Хурал дээр. Тэгээд Ёс зүйн хороонд өгүүлдэг. Би хэзээ ч тийм баталгаагүй, нотолгоогүй худлаа зүйлийг энэ Их Хурал дээр хэлж байгаагүй. Хэрвээ Их Хурал дээр хэлсэн бол намайг Монгол Ардын намынхан бүгдээрээ бариад идчихнэ. Үгүй ёстой аюул болно.

Тийм учраас та энэ асуудлаа залруулахгүй бол, маш хурдан залруулахгүй бол, хөдөлмөрийн гэрээгээр ажилласан энэ их олон хуудас энэ юмыг шалгахгүйгээр би хуурамч тодорхойлолтоор албан тушаалтнуудын нөлөөнд орж энэ тодорхойлолтыг гаргаж өгсөн гэдгээ ойрын үед залруулахгүй бол тэр хүмүүс чинь Үндсэн хуулийн цэцэд өргөдөл өгсөн байна лээ. Үндсэн хуулийн цэц эрх биш тэнд хуульчид байна. Хөдөлмөрийн гэрээгээ, дээрээс нь төрийн албан хаагчаа аж ялгахтайгаа байгаа. Тэндээс дүгнэлт гарна. Би шударгаар шийднэ гэж үзэж байгаа.

Тэгээд шударгаар шийдээд дүгнэлт гарах дээр нь би нэгмөсөн тэр ёс зүйн хороондоо асуудлаа шийдүүлнэ. Тэгээд таныг огцруулах арга хэмжээндээ орно.

Б.Жавхлан: Б.Пүрэвдорж гишүүний хэлснийг анхаараад яваарай.

Гишүүд асуулт асууж дууслаа. Тийм. Сайд гараад явсан. Би зүгээр микрофон дээр үлдээе.

Төсвийн тухай хуулийн 57.3, 57.2. Үүнийг та нар ирэх оны төсөв өргөн барихдаа үүнийгээ өөрчлөхгүй бол баларна шүү. Баларна. Энэ ямар заалт байгааг бүгдээрээ мэдэж байгаа. Тийм ээ.

Улсын төсөв 11 сарын 15-нд батлагдаад, орон нутгийн төсөв 12 сарын 5-нд батлагддаг. Орон нутаг өөрөө удирдах ёсныхоо дагуу 2016-2020 онд Төсвийн тухай хуульд үүссэн өөрчлөлтөөр орон нутгууд төсвийнхөө зарлагыг маш өндөр баталдаг. Орлогоо маш өндөр баталдаг. Сангийн яамныхаа хязгаарт баригдахгүйгээр.

Тэгээд 57.3-аар юу зохицуулдаг вэ гэхээр тэр орон нутгийн том баталсан төсөв нь тухайн жилдээ зарлагадаж дуусахгүй бол улсын төсөв тэр дутуу зардлыг нь хойтон жил нь гаргаж өгөх, алдагдалдаа багтаах ийм үүрэг хүлээдэг.

Яах вэ, төсөв гайгүй жил бол үүнийг нь шингээгээд яваад байдаг юм. Төсөв хүнд жилд нөгөө та нарын арай хийж батлуулсан төсвийн хүрээн дотор байгаа алдагдал чинь орон нутгийн алдагдлуудаар дүүрээд Засгийн газар нэг төгрөгийн ч зардал гаргаж чадахгүй болдог шүү.

Ялангуяа нийслэлийн зардал маш өндөр батлагддаг. Сангийн яаманд захирагдахгүйгээр. Үүнийгээ Сангийн яам төсвийнхөө хязгаарт дотроо оруулж ирж төсвөө баталдаг, орон нутаг нь баталдаг ийм болохгүй бол ирэх жилүүдэд эдийн засгийн нөхцөл байдал ямар ч байгаа билээ. Энэ төсөв чинь явахгүй болно шүү. Энэ дээр бүр онцгой анхаараарай. Энэ протоколд 2025 оны гүйцэтгэлтэй холбогдуулж анхааруулж хэллээ шүү.

Гишүүд үг хэлж асуулт асууж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх Сангийн сайдын танилцуулга болон аудитын тайлан Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчидтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал гишүүн танилцуулна.

Дараагийн асуудалдаа орно. Гүйцэтгэл дууслаа.

Дөрөв.Засгийн газар 2026 оны 5 сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Байнгын хороонд дэд ажлын хэсгийнхэн орж ирэх ёстой шүү. Гишүүдийг хүлээлгээд байна шүү. Дэд ажлын хэсэг нь ч байхгүй, хууль санаачлагч ч байхгүй учраас асуудлыг хойшлууллаа. /алх цохив/

Хяналт шалгалтын тухай хуулийн ажлын хэсэг байгуулагдсан байгаа.

Ажлын хэсэг дахиж ажиллах шаардлагатай байгаа. Иймд хэлэлцүүлэг нь дуусаагүй байгаа юм байна. Ажлын хэсгийн. Иймд энэ долоо хоногт чуулганд орох боломжгүй болж байна шүү. Үүнийг протоколд үлдээлээ. Тийм. Танайх хойшилсон. Хууль санаачлагч байхгүй.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдэж байна. /алх цохив/

Хуралдаанд идэвхтэй оролцсон Байнгын хорооны гишүүдэд талархлаа.

Хуралдаан 1 цаг 29 минут үргэлжилж, 17 цаг 27 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД